

## ТОБИНЫ ТАТВАРЫГ МОНГОЛ УЛСАД НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖ

Б.Энхмаа\* Ч.Энхбаяр\*\*

**Хураангуй.** Санхүүгийн зах зээл байнгын хөдөлгөөнтэй байдаг дэлхийд Тобины татвар нь эдийн засагчид, бодлого боловсруулагчид болон зах зээлд оролцогчдын дунд чухал ач холбогдолтой, маргаантай сэдэв байсаар байна. Үнэт цаасны арилжааны татварыг (цаашид СТТ) нэвтрүүлснээр эрсдэлтэй үнэт цаас багасах нөхцөлд ТОП-20 индекс болон хувьцааны борлуулалтын дүнгийн харилцан хамаарал, гадаад валютын арилжааны татварыг (цаашид СТТ) нэвтрүүлснээр дамын наймаа багасаж, ханшийн хэлбэлзэл багасах нөхцөлд Bid-ask spread аргыг ашиглан нийт ханшийн хөдөлгөөн, худалдан авсан болон худалдсан валютын арилжааны дүнгийн харилцан хамаарлыг log-log загвар болон бусад харилцаа хамаарал тогтоох загваруудыг ашиглан тогтоож, нийт улсын төсөвт 2016-2023 онуудад цугларах боломжтой байсан дүнг тооцоолон гаргав.

**Түлхүүр үгс:** Тобины татвар, санхүүгийн гүйлгээ, үнэт цаас, валютын арилжаа.

## WAYS OF IMPLEMENTING THE TOBIN TAX IN MONGOLIA

**Abstract.** In a world where financial markets remain in constant flux, the Tobin tax continues to be a topic of significance and debate among economists, policymakers, and market participants. In case that risky securities were reduced by implementing Securities Transaction Tax (hereafter STT), the correlation between the TOP-20 index and the amount of stock sales; in case of reduced speculation and rate fluctuations was determined by using Bid-ask spread model, log-log model, and the amount that could be collected in the entire state budget in 2016-2023 was calculated.

**Keywords:** Tobin tax, Financial transaction, securities, foreign exchange trading.

\* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): [Benkhmaa0511@gmail.com](mailto:Benkhmaa0511@gmail.com)

\*\* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): [Enkhbayar.ch@num.edu.mn](mailto:Enkhbayar.ch@num.edu.mn)

## Удиртгал

1972 онд Нобелийн шагналт эдийн засагч Жеймс Тобин нь олон улс дахь валютын ханшийн тогтворгүй байдлыг бууруулахын тулд валютын гүйлгээний татварыг нэвтрүүлэхийг санал болгосон. Эдийн засгийн ном зүйд тус татварыг Тобины татвар гэж нэрлэх болсон. Уг татвар нь Бреттон Вудсын систем нурах нөхцөлд гадаад валютын авах зарах гүйлгээ хийх бүрд нийт дүнгээс бага хэмжээний буюу 0.5-1%-ийн татвар ногдуулж гадаад валютын богино хугацааны дамын наймааг бууруулж, ханшийг тогтворжуулах зорилготой байв (Atanas Pekanov & Margit Schratzenstaller, 2019).

Дэлхий даяар татварыг нэгэн зэрэг нэвтрүүлэх боломжгүй, санхүүгийн гүйлгээний талаарх мэдээллийг цуглуулах мэдээлэл технологи хангалттай хөгжөөгүй гэж үзсэн тул 20-р зууны 80-аад онуудад Тобины тус санал нь газар авсангүй. Гэсэн хэдий ч, дэлхийн эдийн засгийн үе үеийн хямралууд Тобины татварыг бодит практикт нэвтрүүлэх асуудлын талаар дахин дахин хөндсөөр байсан юм. “Тобины татвар” нь анх зөвхөн валютын гүйлгээний татвар гэсэн утгыг агуулж байсан бол тус ойлголт өөрчлөгдөж санхүүгийн салбарын бүх гүйлгээнүүдийг хамарч эхэлсэн.

2008 оны дэлхийн эдийн засгийн хямрал нь Тобины татварыг онолын санаанаас практикт нэвтрүүлэх бодит суурийг тавьж өгсөн. Дэлхийн ихэнх улс орон эдийн засгаа санхүүгийн хямралаас гаргахын тулд асар их мөнгө зарцуулж эхэлсэн. Эдийн засагч нарын үзэж байгаагаар Европын Холбооны улсууд нийт ДНБ-ий 15-20%-ийг улсын төсвөөс гаргаж санхүүгийн байгууллагуудыг дэмжих, санхүүгийн зах зээлийг тогтворжуулахад зориулсан.

Үүний зэрэгцээ олон улс орон Тобины татварын янз бүрийн хувилбаруудыг нэвтрүүлэхээр төлөвлөсөн (Л.П.Гуляева, 2014). Үүнд:

- Валютын арилжааны татвар (Currency transactions tax, Tobin tax, СТТ).
- Санхүүгийн гүйлгээний татвар (Financial Transaction Tax, FTT).
- Банкны үйлчилгээний татвар (Bank transactions tax, ВТТ).
- Үнэт цаасны арилжааны татвар (Securities Transaction Tax, STT).
- Санхүүгийн үйл ажиллагааны татвар (Financial activities tax, FAT).
- Улсын тэмдэгтийн хураамж (Documentary stamp duties, DSD).
- Даатгалын хураамжийн татвар (Insurance premium tax, IPT).
- Хөрөнгийн татвар буюу бүртгэлийн татвар (Registration Tax, RT).

Тобины татвар нь олон улсын валютын тогтвортой байдлыг хангах хэрэгслээс улсын төсвийг бүрдүүлэх арга хэрэгсэл болж хувирсан. Ийнхүү Тобины татвар нь анхны санаанаас холдож, татвар нь өөрөө улс төр, эдийн

засгийн тэмцлийн хэрэгсэл болж хувирсан. Тийм ч учраас орчин үеийн нөхцөлд Тобин татварыг практикт нэвтрүүлэх шалтгаан, зохицуулалтын боломж, хэлбэр, нийгэм, эдийн засгийн болзошгүй үр дагаврыг судлахын ач холбогдол нэмэгдсээр байгаа юм.

2008-2009 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр Монгол улсын эдийн засгийн сэргэлт буурч, уналтад орсон. Энэхүү хямралын үеэр манай улсын эрдэс түүхий эдийн үнэ унасан тул төсвийн орлого буурсан. Энэ уналт нь манай улсын эдийн засгийн бүтэц хэт эмзэг, дархлаа хангалтгүй байгаагийн эхний том анхааруулга байсан юм. Үүнтэй холбоотойгоор 2008 оноос эхлэн ам.доллартой харьцах төгрөгийн ханш улам суларч, 2015 он хүртэл эдийн засгийн өсөлт огцом удааширч гадаад валютын нөөц багассан (Д.Ган-Очир, 2021).

Энэхүү хямралын явцад эдийн засгийн өсөлт сөрөг түвшинд хүрч, Монгол улсын эдийн засаг маш хүнд, эрсдэлтэй байдалд байсан. Монгол улсын Засгийн газраас татвар нэмэх, зардлыг багасгах зэрэг арга хэмжээ аван эдийн засгийн дархлааг сайжруулан тогтворжуулж, улмаар дефолтын эрсдэлээс зайлсхийсэн гэж үзэж болно. Дахин ийм эрсдэлтэй нүүр тулахгүйн тулд Тобины татварыг нэвтрүүлж улсын төсөвт хямралын үед ашиглах нөөцийг нэмэгдүүлэх боломжтой.

### Арга зүйн үндэслэл

Тус судалгааны ажлаар STT буюу үнэт цаасны арилжааны татвар болон СТТ буюу валютын арилжааны татвар дээр судалгаа хийн аль хувилбар нь Монгол улсад тохиромжтой болохыг тогтоохоор хичээсэн болно.

STT-ийн шинжилгээ дээр хамааран хувьсагчаар ТОП-20 индексийн үзүүлэлтийг, харин тайлбарлагч хувьсагчаар хувьцааны арилжааны нийт дүнг сонгон регрессийн шинжилгээ хийсэн. Регрессийн шинжилгээг хоёр үзүүлэлтийн хоорондын статистикийн хамаарлын хэлбэрийг тогтоох зорилгоор энэхүү судалгааны ажилдаа ашигласан болно. Энгийн шугаман регрессийн загвар нь нэг эх олонлогоос сонгогдсон хоёр үзүүлэлтийн хоорондын шугаман хамаарлыг тодорхойлж, прогноз, төлөвлөлт, бодлого боловсруулахад тохиромжтой загвар юм.

Эх олонлогийн регрессийн загвар:

$$Y_i = \beta_1 + \beta_2 X_i \quad (1)$$

**Үүнд:**

$Y_i$  – хамааран хувьсагч,

$X_i$  – тайлбарлагч хувьсагч,

$\beta_1$  – эх олонлогийн  $Y$  тогтмол утга,

$\beta_2$  – эх олонлогийн мэдрэмж.

## Log-Log загвар

Log-Log загварын хувьд регрессийн тэгшитгэлийн тайлбарлагч болон хамааран хувьсагч аль аль нь натурал логарифм утгатай байна.

$$\ln y_i = \beta_1 + \beta_2 \ln x_i \quad (2)$$

Үнэлэгдсэн параметрийн тайлбарыг хийхэд харьцангуй хялбар буюу тайлбарлагч хувьсагч  $x$ -ийн нэг хувиар нэмэгдэхэд хамааран хувьсагч  $y$  дунджаар хэчнээн хувиар өөрчлөгдөхийг харуулдаг. Шинжилгээг Eviews 12 программыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Харин СТГ-ийн шинжилгээ дээр Bid-ask spread аргыг ашиглан шинжилгээ хийсэн.

“Bid-ask spread” арга

Валютын зэх зээл дээрх гүйлгээний өртгийг тооцох нэг арга бол арилжааны банк болон ББСБ-аас харилцагчдад санал болгож буй ханшийн зөрүү дээр суурилдаг (A.Laurin, 2000). Энэ аргыг “Bid-ask spread” загвар гэж нэрлэдэг. Аль ч банк, валютын цэг дээр очиход авах болон зарах ханш гэсэн 2 ханш үйлчилдэг. Өөрөөр хэлбэл валютын арилжааны зах зээлийн үйл ажиллагаа явуулдаг банк болон банк бус байгууллагууд нь худалдаж авах гэсэн үнийн саналаа доод буюу Bid ханшаар, худалдах гэсэн үнийн саналаа дээд буюу Ask ханшаар илэрхийлэн санал болгож байна гэсэн үг юм. Харин Spread бол Bid, Ask 2-ийн зөрүү юм.  $S_b$  болон  $S_a$  нь төгрөгийн ам.доллаароор илэрхийлсэн авах зарах ханшийг тэмдэглэе. Зах зээлд оролцогч ямар нэгэн гүйлгээний нэмэлт зардал төлөөгүй гэж үзэн нэг төгрөгийн нэгжийн ханшийг  $S$  гэж тэмдэглэе. Тэгвэл доорх тэгшитгэлүүдийг

$$\frac{S - S_b}{S} = C \leftrightarrow S_b = S(1 - C) \quad (3)$$

$$\frac{S_a - S}{S} = C \leftrightarrow S_a = S(1 + C) \quad (4)$$

1 болон 2 дугаар тэгшитгэлийг  $S$  гишүүнээс суллах үед дараах тэгшитгэлийг гарган авах боломжтой юм:

$$C = \frac{S_a - S_b}{S_a + S_b} \quad (5)$$

## Судалгааны үр дүн

### STT буюу үнэт цаасны арилжааны татварын судалгаа

Судалгааг хийхдээ 2016-2023 оны Монголын хөрөнгийн биржийн Топ-20 индексийн жил бүрийн дундаж үзүүлэлт болон тус онуудын нийт хувьцааны борлуулалтын трендийг шинжлэх замаар хийсэн болно.

#### Хүснэгт 1. Тодорхойлогч статистик

	Obs	Mean	Std.dev	Min	Max
ТОП 20 индекс	94	23,776.89	9,971.57	10,849.85	44,824.39
Нийт арилжааны дүн /сая төгрөг/	94	45,725.05	79,213.50	524.47	533,685.10

Эх сурвалж: Eviews программ, тодорхойлогч статистикийн шинжилгээний үр дүн

Тодорхойлогч статистикийн үзүүлэлтийн үр дүнгээс харвал 8-н жилийн буюу 2016-2023 онуудын 94 сарын ажиглалтын утгаас ТОП-20 индексийн дундаж нь 23,776.89, хамгийн их утга 44,824.39, хамгийн бага утга 10,849.85, нийт хувьцааны арилжааны дундаж нь 45,725.05, хамгийн их утга 533,685.10, хамгийн бага утга 524.47 гарсан байна.

Харийн тус 2 үзүүлэлтүүдийн хамаарлыг корреляцийн шинжилгээгээр тодорхойлсон ба Хүснэгт 2-с харах боломжтой.

#### Хүснэгт 2. Корреляцийн шинжилгээний үр дүн

	TOP20	Total amount
TOP20	1	
Total amount	0.314354967	1

Эх сурвалж: Eviews программ, корреляцийн шинжилгээний үр дүн

Корреляцийн коэффициент нь  $-1 \leq r < 0$  бол сөрөг хамааралтай,  $r = 0$  шугаман хамааралгүй,  $0 < r \leq 1$  бол эерэг хамааралтай болохыг илэрхийлэх бөгөөд шинжилгээний үр дүнгээр тус 2 үзүүлэлтүүд нь эерэг хамааралтай болохыг харуулж байна.

#### Хүснэгт 3. Регрессийн шинжилгээ

Multiple R	0.314354967
R Square	0.098819045
Adjusted R Square	0.0890236
Standard Error	0.571357411
Observations	94
Significance	0.002031233

Эх сурвалж: Eviews программ, регрессийн шинжилгээний үр дүн

ТОП 20 индексийн үзүүлэлт 1 хувиар өсөх тохиолдолд нийт хувьцааны арилжаа ойролцоогоор 31.4 хувиар өсөхөөр байгааг харуулж байна. Детерминацийн коэффициентийг эконометрикт  $R^2$  гэж тэмдэглэдэг бөгөөд үнэлэгдсэн регрессийн тэгшитгэлийн утга бодит утгын хэдэн хувийг тайлбарлаж байгааг харуулдаг ба  $0 \leq R^2 \leq 1$  байдаг. Үр дүнгээс  $R^2 = 0.09881$  байгаа нь хамааран хувьсагчийн хэлбэлзлийн дөнгөж 10 хувь нь л энэ тайлбарлагч хувьсагчаар илэрхийлэгдэж байна. Тус регрессийн ач холбогдол нь 0.002 байгаа ба энэ үзүүлэлт 0.005-аас бага байгаа тохиолдолд статистикийн хувьд ач холбогдолтой гэж үздэг.

Сүүлийн хэдэн жилүүдэд Монгол улсад хөрөнгийн зах зээл асар их хурдтай хөгжиж байна. Монгол улсад Тобины татварын хувийг 0.1 хувиар тогтоож өгөхөд л зөвхөн хувьцааны арилжаанаас улсын төсвийн орлого Хүснэгт 4-т үзүүлсэн байдлаар нэмэгдэн, нөөц үүсгэх боломжоор хангах байсан.

Хүснэгт 4. Тобины татвар нэвтрүүлэх тохиолдолд улсын орлогын тооцоолол /сая төгрөг/

Он	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Хувьцааны арилжааны нийт дүн	12,604.3	62,126.8	60,349.3	23,181.5	62,873.1	109,110.8	144,746.5	97,586.9
Ногдох татварын дүн	63.0	310.6	301.8	115.9	314.4	545.6	723.7	487.9
Бонд болон бусад үнэт цаасны арилжааны нийт дүн	5,422.4	40,450.0	1,996.7	-	30,000.0	241,125.1	310.3	1,010.4
Ногдох татварын дүн	5.4	40.5	2.0	-	30.0	241.1	0.3	1.0
Нийт арилжааны дүн	18,026.7	102,576.9	62,346.1	23,181.5	92,873.1	350,235.9	145,056.7	98,597.2
Нийт улсын төсөвт цуглуулах татварын дүн	68.4	351.1	303.7	115.9	344.4	786.7	724.0	488.9


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, судлаачийн тооцоолол

Тус тооцоолоос харахад 2016-2023 онуудад нийт 3.2 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт цуглуулах боломжтой байна.

### СТТ буюу валютын арилжааны татварын судалгаа


Судалгааг хийхдээ 2020-2023 оны Худалдаа хөгжлийн банкны авах зарах болон Монгол банкны албан ханшийг ашигласан болно. Тус авч үзсэн хугацаанд гадаад валютын ханшийн хөдөлгөөнийг Зураг 1-ээс харах боломжтой. Bid-ask spread аргыг ашиглан авах зарах үнийн хоорондын зөрүү болох Spread-ийг тодорхойлон графикаар дүрсэлснийг Зураг 2-оос харах боломжтой. USD болон CNY валютуудын Spread нь харьцангуй тогтмол байх бол JPY болон KRW валютуудын Spread байнгын өөрчлөгдөж байгаа нь харагдаж байна.

Зураг 1. Ханшийн хөдөлгөөн



Эх сурвалж: Монгол банк, Худалдаа Хөгжлийн Банк

Зураг 2. Spread-ийн хөдөлгөөн



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Bid-ask spread аргын тэгшитгэл 5-ийг ашиглан 2020-2023 онуудын валютын арилжааны гүйлгээний өртгийг тооцоолбол дараах байдалтай байна.

Хүснэгт 5. Bid-ask spread аргаар хийсэн шинжилгээ

	USD		CNY		JPY		KRW	
	Нийт арилжааны дүн	C	Нийт арилжааны дүн	C	Нийт арилжааны дүн	C	Нийт арилжааны дүн	C
2020	1324.8	0.00131	1452.4	0.00466	34.4	0.01476	34.7	0.02181
2021	2,008.40	0.00123	1939.4	0.00428	33.7	0.01333	52.1	0.02382
2022	4,155.80	0.00152	4,305.90	0.01074	357.7	0.01898	80.3	0.02621
2023	1671.7	0.00144	1,980.50	0.00877	245.4	0.01619	54.8	0.02604

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Үүний дараагаар валют тус бүрийн үзүүлэлтүүд дээр C буюу гүйлгээний өртгийг хамааран хувьсагчаар, нийт арилжааны дүнг тайлбарлагч хувьсагчаар сонгон log-log загвар ашиглан регрессийн шинжилгээг хийв.



*Хүснэгт 6. Регресс болон корреляцийн шинжилгээ*

	USD	CNY	JPY	KRW
Multiple R	0.6179076	0.776915856	0.905814684	0.895174503
R Square	0.381809802	0.603598248	0.820500242	0.80133739
Standard Error	0.47550052	0.358974265	0.653063043	0.187362472
Correlation	0.683426323	0.811107453	0.947119466	0.848953557

*Эх сурвалж: Eviews программ, регрессийн шинжилгээний цр дүн*

Валют тус бүрийн арилжааны нийт дүн нь гүйлгээний өртөгтэй маш өндөр корреляцийн хамааралтай байгааг Хүснэгт 5-аас харах боломжтой байна. Мөн регрессийн шинжилгээний утгууд ч гэсэн эерэг, ач холбогдолтой гарсан байна. Гүйлгээний өртгийн өөрчлөлт нь валютын ханшийн хэлбэлзлээс маш их хамаарч байна. Үр дүнгээс харахад гүйлгээний өртөг өсөх нь арилжааны хэмжээг бууруулахад хүргэж байна. Мөн 2022 оны арилжааны өсөлт нь Ковид-19 цар тахлын нөлөөтэй шууд хамааралтай, хилийн хаалт хоригууд цуцлагдсаны дараагаар хийгдсэн байгаа нь харагдаж байна. Тобины татварыг нэвтрүүлэн, ханшийн хэлбэлзлийг тогтворжуулах үед гүйлгээний өртөг нь мөн тогтворжин валютын арилжааны дүн нэмэгдэнэ хэмээн үзэж байна.

СТТ-ийг хамгийн бага буюу 0.1 хувиар тогтоон 2020-2023 онуудад цугларах боломжтой байсан татварын дүнг буюу улсын төсөвт нөөц үүсгэж болгох орлогын хэмжээг тооцон Хүснэгт 6-т харуулав.

*Хүснэгт 7. СТТ тооцооллын дүн /тэрбум төгрөг/*

Валют	2020		2021		2022		2023	
	Авсан	Зарсан	Авсан	Зарсан	Авсан	Зарсан	Авсан	Зарсан
USD	663.5	661.3	994.1	1,014.3	2,076.5	2,079.3	866.4	805.3
CNY	734.5	717.9	964.8	974.6	2,094.2	2,211.7	979.0	1,001.5
EUR	107.8	104.1	130.6	138.7	308.2	360.6	49.6	45.9
JPY	19.6	14.8	16.6	17.1	179.2	178.5	124.0	121.4
KRW	18.0	16.7	26.0	26.1	39.3	41.0	27.3	27.5
Бусад	22.9	18.7	16.4	16.0	136.3	166.0	127.0	130.5
Нийт	1,566.3	1,533.5	2,148.5	2,186.8	4,833.7	5,037.1	2,173.3	2,132.1
Татвар	1.6	1.5	2.1	2.2	4.8	5.0	2.2	2.1

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, судлаачийн тооцоолол*

Тус тооцооллоос харахад 2020-2023 онуудад нийт 21.6 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт цуглуулах боломжтой байна.

## Дүгнэлт

Судалгааны үр дүн дээр үндэслэн хэд хэдэн дүгнэлт гаргах боломжтой байна. Эдгээр нь:

1. Тобины татвар нь хямралын үед эдийн засгийг тогтворжуулах, санхүүгийн салбарын үйл ажиллагааг тасралтгүй явуулах зардлыг нөхөхийн тулд хэрэгтэй гэж үздэг;
2. Европын холбооны ихэнх орнууд Тобины татварыг өөрийн орны эдийн засагт тохирсон хувилбарыг нэвтрүүлсэн байна. Иймд санхүүгийн салбарын үр ашигтай үйл ажиллагаа, ил тод өрсөлдөх байдлыг хангахын тулд бусад улс орнууд мөн татварын орчныг ижил түвшинд хүргэх хэрэгтэй;
3. Улсын төсөвт орлогын шинэ эх үүсвэр бий болгох хэрэгцээ;
4. Санхүүгийн зах зээлийн үр ашгийг бууруулж, тогтворгүй болгож буй богино хугацааны, өндөр эрсдэлтэй санхүүгийн гүйлгээг хязгаарлаж, хэмжээг нь бууруулах юм;
5. Үнэт цаасны арилжаа болон гадаад валютын арилжааны дүнгүүдийг харьцуулбал валютын арилжаа нь манай улсад хамаагүй их хийгддэг байна.
6. СТТ-ийг бодвол СТТ-ийн шинжилгээний үр дүн хамаагүй ач холбогдолтой гарсан тул Монгол улсад эхний ээлжид СТТ-ийг нэвтрүүлэн ашиглах боломжтой байна.

Эдийн засгийн өсөлт тогтворгүй байгаа өнөөгийн нөхцөлд санхүүгийн салбарын тогтвортой хөгжил чухал бөгөөд зөвхөн валютын арилжаа төдийгүй санхүүгийн бусад гүйлгээнд хяналт тогтоох, төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зэрэгт Тобины татвар нь өөрийн гэсэн үүрэг рольтой байх боломжтой юм. Хямралын үед санхүүгийн салбарыг тогтворжуулах зорилгоор тус татварыг нэвтрүүлэн, төсвийн нөөцөө нэмэгдүүлэн Монгол улсын эдийн засгийн дархлааг тогтоож, эрсдэлээс сэргийлэх маш чухал бодлого хэмээн миний хувьд үзэж байна.

**Ашигласан материал**

Alexandre Laurin (2000). Foreign exchange markets and the Tobin tax.

Atanas Pekanov & Margit Schratzenstaller (2019). A Global Financial Transaction Tax Theory, Practice and Potential Revenues.

Suzanne de Brunhoff & Bruno Jetin (2021). The Tobin Tax and the Regulation of Capital Movements.

Ган-Очир Д. (2021). Монгол улсын эдийн засгийг тогтворжуулах бодлого, загварчлалын асуудал.

Гуляева Л.П. (2014). Мировой опыт налогообложения финансовых операций для обеспечения социально ориентированного развития финансового сектора экономики.

Гуляева Л.П. (2014). Применение налога тобина для регулирования современных финансовых рынков: причины, социально-экономические последствия.